



МОНГОЛ УЛС  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх,  
сонгон шалгаруулах журам батлах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалт, 79 дүгээр зүйлийн 79.1, 79.5 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.“Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулгын загвар”-ыг 2 дугаар хавсралтаар, “Шүүгчид нэр дэвшигчийн талаарх илтгэгч гишүүний тайлангийн загвар”-ыг 3 дугаар хавсралтаар, “Нэр дэвшигчийн мэргэшил, чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийн загвар”-ыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.“Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Р.Батрагчаа/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүний ёс зүй болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх дүрэм батлах тухай” Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 14 дүгээр тогтоол, “Шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалтын арга, хэлбэр, үнэлэх аргачлал батлах тухай” 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 31 дүгээр тогтоол, “Шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалтын арга, хэлбэр, үнэлэх аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 54 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ

011000476

Шүүхийн ерөнхий зөвлөлийн  
2022 оны 5 дугаар тогтоолын 1  
дүгээр хавсралт

**ШҮҮГЧИД ТАВИХ БОЛЗОЛ, ШААРДЛАГЫГ ҮНЭЛЭХ,  
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ** УХА.00052 1701517

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам /цаашид “журам” гэх/-ын зорилго нь анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тавих болзол, шаардлагад нийцүүлэн шүүгчид нэр дэвшигчээс бүрдүүлэх баримт бичиг, бүртгэл, шалгалт авах арга, хэлбэр, үнэлэх аргачлал, нэр дэвшигчийн мэргэшил, чадвар, нэр хүндийн талаар дүгнэлт гаргах, олон нийтээс санал хүлээн авах болон холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2.Шүүхийн ерөнхий зөвлөл /цаашид “Ерөнхий зөвлөл” гэх/ Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан шүүхийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэх хууль зүйн мэдлэг, чадвар, мэргэшил, ёс зүй, зан төлөвтэй хуульчийг шилж олох, сонгон шалгаруулах, шүүгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу хэрэгжүүлнэ.

1.3.Шүүгчийн сонгон шалгаруулалт /цаашид “сонгон шалгаруулалт” гэх/ олон нийтэд ил тод байх бөгөөд шалгалттай холбогдуулан гаргасан Ерөнхий зөвлөлийн шийдвэр үндэслэл бүхий, оролцогч болон сонирхогч этгээдэд ойлгомжтой, нээлттэй байна.

**Хоёр.Сонгон шалгаруулалтын зарчим**

2.1.Сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод, хараат бус байх, хууль дээдлэх зарчмыг баримтлан зохион байгуулна.

2.2.Сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулахад энэ журмын 2.1-д заасан зарчмыг нэгэн адил баримтална.

2.3.Шалгалтын даалгавар боловсруулах ажиллагаа хараат бус байна.

**Гурав.Шүүгчийн сонгон шалгаруулалтын зар**

3.1.Ерөнхий зөвлөл шүүгчийн сонгон шалгаруулалтын зарыг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасан хугацаанд өөрийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тухай бүр, хүртээмжтэй хэлбэрээр мэдээлнэ.

3.2.Шүүгчийн сонгон шалгаруулалтын зард дараах зүйлийг тусгана:

3.2.1.шүүгчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх хуульд заасан болзол, шаардлага;

3.2.2.шүүгчид нэр дэвшигчийн өргөдөл, хавсралт баримт бичгийн жагсаалт, тэдгээрийг хүлээн авах хугацаа, хэлбэр, хаяг;

3.2.3.шүүгчид нэр дэвшигчийг бүртгэх хугацаа;

3.2.4.сонгон шалгаруулалтын хугацаа, хуваарь;

3.2.5.сонгон шалгаруулалтын журам, шалгалтын хэлбэр;

3.2.6.сонгон шалгаруулалт зохион байгуулах газрын хаяг, холбоо барих мэдээлэл.

3.3.Иргэн анхан шатны шүүхийн шүүгчид тавих болзол, шаардлага хангасан тухай дараах баримт бичгийг эх хувиар, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өргөдөлд хавсаргана:

3.3.1.хууль зүйн дээд боловсролын диплом;

3.3.2.хуульчаар гурваас доошгүй жил ажилласан хөдөлмөр эрхлэлтийн талаарх нотлох баримт буюу нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, эсхүл нийгмийн даатгалын лавлагаа;

3.3.3.эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай Цагдаагийн ерөнхий газрын лавлагаа;

3.3.4.шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй тухай Монгол Улсын ерөнхий прокурорын газрын лавлагаа;

3.3.5.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл /хуульчийн гэрчилгээ/;

3.3.6.төрийн албан хаагчийн анкет;

3.3.7.Ерөнхий зөвлөлөөс баталсан маягтын дагуу гаргасан мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга, түүний хавсралт;

3.3.8.оршин суугаа газрын тухайн баг, хорооны Засаг даргын тодорхойлолт, Монгол Улсын иргэний үнэмлэх;

3.3.9.гэр бүлийн болон эд хөрөнгийн эрхийн лавлагаа;

3.3.10.шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадалгаа;

3.3.11.Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг.

3.4.Иргэн давж заалдах шатны шүүхийн шүүгчид тавих болзол, шаардлага хангасан тухай дараах баримт бичгийг эх хувиар, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өргөдөлд хавсаргана:

3.4.1.шүүгч нэрээ дэвшүүлж байгаа бол энэ журмын 3.3.3, 3.3.4, 3.3.6, 3.3.7, 3.3.9-3.3.11-д заасан баримт бичиг;

3.4.2.шүүгчээс бусад хуульч нэрээ дэвшүүлж байгаа бол энэ журмын 3.3-т заасан баримт бичиг;

3.4.3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасны дагуу анхан шатны шүүхэд шүүгчээр зургаагаас доошгүй жил ажилласан тухай нотлох баримт.

3.5.Иргэн Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид тавих болзол, шаардлага хангасан тухай дараах баримт бичгийг эх хувиар, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өргөдөлд хавсаргана:

3.5.1.шүүгч нэрээ дэвшүүлж байгаа бол энэ журмын 3.3.3, 3.3.4, 3.3.6, 3.3.7, 3.3.9-3.3.11-д заасан баримт бичиг;

3.5.2.шүүгчээс бусад хуульч нэрээ дэвшүүлж байгаа бол энэ журмын 3.3-т заасан баримт бичиг;

3.5.3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт заасан шаардлагын аль нэгийг хангасан тухай нотлох баримт.

3.6.Өргөдөлд сонгон шалгаруулалттай холбоотой мэдээлэл, шийдвэр хүлээн авах цахим шуудангийн хаяг, харилцах утас, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсэгт заасан албан тушаалыг сүүлийн 6 жил эрхлээгүй тухай болон нэр дэвшигчийн талаар эрх бүхий байгууллагаас лавлагаа, тодруулга авахыг зөвшөөрөх эсэх талаар бичсэн байна.

3.7.Сонгон шалгаруулалтын зард дурдаагүй баримт бичгийг нэр дэвшигчээс шаардахгүй.

3.8.Ерөнхий зөвлөл шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулалтын зарыг тухайн шүүгчийн ажиллах аймаг, нийслэлийн өдөр тутмын хэвлэлд нийтэлж болно.

3.9.Монгол Улсын дээд шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтыг зарлахдаа Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт заасныг үндэслэнэ.

### **Дөрөв.Шүүгчид нэр дэвшигчийг бүртгэх**

4.1.Шүүгчид тавих болзол, шаардлагыг хангасан иргэн шүүгчид нэрээ дэвшүүлэх тохиолдолд сонгон шалгаруулалтын тухайн зард дурдсан өргөдөл, баримт бичиг /цаашид "баримт бичиг" гэх/-ийг дурдсан хугацаанд багтаан Ерөнхий зөвлөлд цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

4.2.Ерөнхий зөвлөл өргөдөл гаргагч иргэний баримт бичгийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор өргөдөл, хавсралт баримт бичгийг нягтлан шалгах дараах ажиллагаа явуулна:

4.2.1.баримт бичиг сонгон шалгаруулалтын зард заасан хугацаанд ирсэн эсэх, бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхийг нягтлан шалгах, шаардлагатай тохиолдолд тухайн баримт бичгийн талаар эрх бүхий холбогдох байгууллагаас лавлагаа, тодруулга авах;

4.2.2.иргэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан тухайн шатны шүүхийн шүүгчид тавих болзол, шаардлагыг хангасан эсэхийг нягтлан шалгах, шаардлагатай тохиолдолд эрх бүхий холбогдох байгууллагаас лавлагаа, тодруулга авах.

4.3.Ерөнхий зөвлөл анхан шатны шүүхийн шүүгчид нэрээ дэвшүүлсэн өргөдөл гаргагч иргэний баримт бичгийг нягтлан шалгаж доор дурдсан үндэслэлийн аль нэг байгаа тохиолдолд шүүгчид нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай тогтоол гаргана:

4.3.1.иргэн өргөдөл, баримт бичгээ сонгон шалгаруулалтын зард заасан хугацаанд ирүүлээгүй;

4.3.2.энэ журмын 3.3-т заасан баримт бичгийн аль нэг нь дутуу;

4.3.3.өргөдөл гаргагч иргэний баримт бичиг үнэн зөв бус;

4.3.4.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзлыг хангаагүй;

4.3.5.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1-31.1.4 дэх заалт, 31.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй.

4.4.Ерөнхий зөвлөл давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэрээ дэвшүүлсэн иргэний баримт бичгийг нягтлан шалгаж дараах үндэслэлийн аль нэг байгаа тохиолдолд шүүгчид нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай тогтоол гаргана:

4.4.1.энэ журмын 4.3.1, 4.3.3-4.3.5-д заасан үндэслэл;

4.4.2.энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан баримт бичгийн аль нэг нь дутуу;

4.4.3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 31.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй.

4.5.Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхийн шүүгчид нэрээ дэвшүүлсэн өргөдөл гаргагч иргэний баримт бичгийг нягтлан шалгаж дараах үндэслэлийн аль нэг байгаа тохиолдолд нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай тогтоол гаргана:

4.5.1.энэ журмын 4.3.1, 4.3.3-4.3.5-д заасан үндэслэл;

4.5.2.энэ журмын 3.5.1, 3.5.2-т заасан баримт бичгийн аль нэг нь дутуу;

4.5.3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, 31.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй.

4.6.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан үнэлгээ нь хүчинтэй байгаа

нэр дэвшигч сонгон шалгаруулалтад нэрээ дэвшүүлэх, бүртгүүлэх эрхтэй. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэх үед үнэлгээний хүчинтэй байх хугацаа нь дуусаагүй боловч шалгалт өгөх болон эрэмбэлэх үед хүчинтэй байх хугацаа нь дууссан нэр дэвшигчийг нэр дэвшүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

4.7.Ерөнхий зөвлөл өргөдөл гаргагч иргэний баримт бичгийг нягтлан шалгаж энэ журмын 4.3-4.5-д дурдсан холбогдох үндэслэлийн аль нэг нь тогтоогдоогүй бол шүүгчид нэр дэвшигчээр бүртгэсэн тухай тогтоол гаргана.

4.8.Ерөнхий зөвлөл Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 34.5 дахь хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн баримт бичиг, мэдээллийг өөрийн болон тухайн шүүхийн, түүнчлэн нутгийн захиргааны байгууллагын цахим хуудаст байршуулж, олон нийтийг сонгон шалгаруулалтын мэдээллээр хүртээмжтэй хэлбэрээр хангаж, нэр дэвшигчийн талаар санал ирүүлэх боломжийг бүрдүүлнэ

4.9.Нэр дэвшигчийн баримт бичиг үнэн зөв бус болох нь сонгон шалгаруулалтын явцад тогтоогдвол Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийн бүртгэлийг хүчингүй болгох, шалгалтыг зогсоох, үнэлгээ, гүйцэтгэлийг хүчингүй болгох зэрэг шийдвэр гаргана.

4.10.Нэр дэвшигч эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад нэг зэрэг нэрээ дэвшүүлж болно.

### **Тав.Хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт**

#### **5.1.Анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт**

5.1.1.Анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт дараах төрөл, арга, хугацаа, үнэлэх оноотой байна:

5.1.1.1.Үндсэн хуулийн эрх зүйн мэдлэгийг сорилын асуултад хариулах аргаар 60 минутын хугацаанд шалгах, 15 хүртэл оноогоор үнэлэх;

5.1.1.2.эрх зүйн баримт бичиг боловсруулах болон хэл найруулга, бичгийн чадварыг тодорхой тохиолдол өгч түүний талаар шүүхээс гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах аргаар 150 минутын хугацаанд шалгах, 15 хүртэл оноогоор үнэлэх;

5.1.1.3.салбар эрх зүйн хууль хэрэглэх мэдлэг, чадварыг эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 25 хүртэл оноогоор үнэлэх. Эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол тухайн салбар эрх зүйн чиглэлээр тохиолдол шийдвэрлэнэ. Эрүү, иргэний хэргийг хамт шийдвэрлэдэг анхан шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол нэр дэвшигч эдгээр салбар эрх зүйн аль чиглэлээр тохиолдол шийдвэрлэхийг сугалаагаар тодорхойлно;

5.1.1.4.салбар эрх зүйн мэдлэгийг сорилын асуултад хариулах аргаар 60 минутын хугацаанд шалгах, 15 хүртэл оноогоор үнэлэх. Эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол тухайн салбар эрх зүйн чиглэлээр сорилын асуултад хариулна. Эрүү, иргэний хэргийг хамт шийдвэрлэдэг анхан шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол нэр

дэвшигч эдгээр салбар эрх зүйн аль чиглэлээр сорилын асуултад хариулахыг сугалаагаар тодорхойлно.

## **5.2.Давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт**

5.2.1.Давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт дараах төрөл, арга, хугацаа, үнэлэх оноотой байна:

5.2.1.1. магадлал бичих чадварыг эрх зүйн баримт бичиг боловсруулах аргаар 120 минутын хугацаанд шалгах, 15 хүртэл оноогоор үнэлэх. Эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол тухайн салбар эрх зүйн чиглэлээр баримт бичиг боловсруулна. Эрүү, иргэний хэргийг хамт шийдвэрлэдэг давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол нэр дэвшигч эдгээр салбар эрх зүйн аль чиглэлээр эрх зүйн баримт бичиг боловсруулахыг сугалаагаар тодорхойлно;

5.2.1.2. хууль хэрэглэх мэдлэг, чадварыг эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 25 хүртэл оноогоор үнэлэх. Эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол тухайн салбар эрх зүйн чиглэлээр тохиолдол шийдвэрлэнэ. Эрүү, иргэний хэргийг хамт шийдвэрлэдэг давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол нэр дэвшигч эдгээр салбар эрх зүйн аль чиглэлээр тохиолдол шийдвэрлэхийг сугалаагаар тодорхойлно;

5.2.1.3. шүүн таслах ажлын туршлагыг анхан шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 20 хүртэл оноогоор үнэлэх. Эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол тухайн салбар эрх зүйн чиглэлээр шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийнэ. Эрүү, иргэний хэргийг хамт шийдвэрлэдэг давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол нэр дэвшигч эдгээр салбар эрх зүйн аль чиглэлээр шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхийг сугалаагаар тодорхойлно;

5.2.1.4. салбар эрх зүйн хууль тогтоомжийн мэдлэгийг сорилын асуултад хариулах аргаар 60 минутын хугацаанд шалгах, 10 хүртэл оноогоор үнэлэх.

## **5.3.Хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт**

5.3.1.Хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт дараах төрөл, арга, хугацаа, үнэлэх оноотой байна:

5.3.1.1. Үндсэн хуулийн эрх зүйн онол, мэдлэгийг эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргаар 120 минутын хугацаанд шалгах, 10 хүртэл оноогоор үнэлэх;

5.3.1.2. хууль тайлбарлах мэдлэг, чадварыг хууль тайлбарлан хэрэглэх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 15 хүртэл оноогоор үнэлэх. Нэр дэвшигч аль салбар эрх зүйн чиглэлээр хууль тайлбарлахаа сонгоно;

5.3.1.3. шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх чадварыг анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд дүн шинжилгээ хийх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 15 хүртэл оноогоор үнэлэх. Нэр дэвшигч аль салбар эрх зүйн чиглэлээр шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхээ сонгоно;

5.3.1.4. хууль хэрэглэх мэдлэг, чадварыг эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 15 хүртэл оноогоор үнэлэх. Нэр дэвшигч аль салбар эрх зүйн чиглэлээр эрх зүйн тохиолдол шийдвэрлэхээ сонгоно;

5.3.1.5. эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг хяналтын журмаар болон бусад асуудлыг хянан шийдвэрлэх мэдлэгийг сорилын асуултад хариулах аргаар 90 минутын хугацаанд шалгах, 15 хүртэл оноогоор үнэлэх.

#### **5.4. Хууль зүйн мэдлэг, чадварын шалгалттай холбоотой бусад асуудал**

5.4.1. Нэр дэвшигчийг үнэлэхдээ аравны нарийвчлалтай оноо өгч болно. Нийт гишүүний үнэлгээний дунджаар нэр дэвшигчийн шалгалт тус бүрийн үнэлгээг зууны нарийвчлалтай гаргана.

5.4.2. Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтын даалгаврыг боловсруулахдаа тухайн чиглэлээр мэргэшсэн хөндлөнгийн хараат бус шинжээчийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.11 дэх хэсэгт заасны дагуу оролцуулж болно.

5.4.3. Ерөнхий зөвлөлийн гишүүн эрх зүйн тохиолдол шийдвэрлэх, эрх зүйн баримт бичиг боловсруулах, хууль тайлбарлан хэрэглэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргаар авсан шалгалтын хариуг үнэлэхдээ тухайн шалгалтын даалгаврыг зохиосон Ерөнхий зөвлөлийн гишүүн, эсхүл хөндлөнгийн хараат бус шинжээчийн хариулт, аргачлалыг баримтална.

5.4.4. Ерөнхий зөвлөл Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад 50, түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг тухайн шалгалтад тэнцсэнд тооцож, тогтоол гарган мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад оруулна.

#### **Зургаа. Мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалт**

##### **6.1. Мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалт**

6.1.1. Мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтыг дараах журмын дагуу авна:

6.1.1.1. нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг үнэлсэн тайланг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсэгт заасны дагуу, нэр дэвшигчийн мэргэшил, чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг 34.7.3 дахь заалтад заасны дагуу гаргуулахаар нэр дэвшигчийг тохиолдлын журмаар Ерөнхий зөвлөлийн нэг, эсхүл түүнээс дээш тооны гишүүн /цаашид "илтгэгч гишүүн" гэх/-д тэнцвэртэй хуваарилах;

6.1.1.2. нэр дэвшигчийн баримт бичиг, мэдээллийг энэ журмын 4.8-д заасны дагуу цахим хуудаст байршуулснаас хойш 14 хоногийн дотор нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг сонирхсон этгээдээс хүлээн авах;



6.1.1.3.хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцсэн нэр дэвшигчийн мэргэшил, чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлт гаргах;

6.1.1.4.Ерөнхий зөвлөл нэр дэвшигчтэй ярилцлага хийх;

6.1.1.5.Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг үнэлэх;

6.1.1.6.Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийг нийлбэр онооны дарааллаар эрэмбэлэх.

## **6.2.Илтгэгч гишүүн нэр дэвшигчийг судалж үнэлэх**

6.2.1.Илтгэгч гишүүн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсэгт заасныг судалж нэр дэвшигч шүүгчид тавих болзол, шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлж, нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг үнэлж энэ журмын 6.7.2, 6.7.3-т заасан шалгуурын дагуу үндэслэл бүхий тайлан бичнэ.

6.2.2.Илтгэгч гишүүн нэр дэвшигчийн баримт бичгийг судлахдаа ирүүлсэн баримт бичгийг үндэслэнэ.

6.2.3.Илтгэгч гишүүн нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийн талаар мэдээлэл авах зорилгоор дараах арваас доошгүй хүнтэй ярилцлага хийж, тэмдэглэл хөтөлнө:

6.2.3.1.нэр дэвшигч хуульчийн хувиар оролцсон хэрэг, маргаанд хамтран ажилласан хуульч болон эсрэг талын хуульч;

6.2.3.2.нэр дэвшигчийг удирдан ажиллаж байсан, эсхүл ажиллаж байгаа хүн;

6.2.3.3.нэр дэвшигчийн удирдлагад ажиллаж байсан, эсхүл ажиллаж байгаа хүн;

6.2.3.4.нэр дэвшигчтэй хамтран ажиллаж байсан, эсхүл ажиллаж байгаа хүн;

6.2.3.5.нэр дэвшигчид хичээл зааж байсан хууль зүйн сургуулийн багш;

6.2.3.6.Монголын хуульчдын холбоо, эсхүл Монголын өмгөөлөгчдийн холбооны эрх бүхий ажилтан;

6.2.3.7.шаардлагатай гэж үзсэн бусад хүн.

6.2.4.Илтгэгч гишүүн энэ журмын 6.2.3-т заасан хүнтэй ярилцлага хийхдээ Ерөнхий зөвлөлөөс урьдчилан гаргасан жишиг асуултыг ашиглаж болох бөгөөд биечлэн ярилцах, шаардлагатай тохиолдолд утас, цахим шуудан, цахим уулзалт зэрэг бусад хэлбэрийг ашиглаж болно.

6.2.5. Илтгэгч гишүүн ярилцлага хийхдээ тухайн этгээдэд дараах мэдээллийг заавал өгнө:

6.2.5.1. нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийн талаар мэдээлэл өгсөн хуульч, бусад этгээд өөрсдөө задруулахыг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тэдний нэр, холбогдох мэдээллийг илтгэгч гишүүн болон Ерөнхий зөвлөлийн бусад гишүүн нууцлах үүрэг хүлээсэн тухай;

6.2.5.2. нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийн талаар мэдээлэл өгсөн хуульч, бусад этгээд нэр дэвшигчийн нэр, ярилцлагын агуулгыг нууцлах үүрэгтэй тухай.

### **6.3. Илтгэгч гишүүн нэр дэвшигчтэй ярилцлага хийх**

6.3.1. Илтгэгч гишүүн нэр дэвшигчтэй ганцаарчилсан ярилцлага хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд цахим уулзалт хийж болно.

6.3.2. Илтгэгч гишүүн нэр дэвшигчтэй ярилцлага хийхдээ цугларсан сөрөг болон бусад тайлбар, мэдээллийн үндэслэл, нөхцөл байдлыг нэр дэвшигчид боломжит хэмжээнд мэдэгдэж хариу тайлбар өгөх боломжоор хангана.

6.3.3. Нэр дэвшигчийн талаар сөрөг тайлбар, мэдээлэл өгсөн хүн өөрийгөө нэр дэвшигчид мэдэгдэхийг зөвшөөрөөгүй бөгөөд уг сөрөг тайлбар, мэдээллийн агуулгыг нэр дэвшигчид мэдэгдэх нь ярилцлага өгсөн хүний нууцлалыг задруулах эрсдэлд хүргэх тохиолдолд илтгэгч гишүүн уг сөрөг тайлбар, мэдээллийг нэр дэвшигчид хэлэхийг хориглоно. Нэр дэвшигчид өөрт нь танилцуулаагүй сөрөг тайлбарыг үнэлгээнд ашиглахгүй.

### **6.4. Илтгэгч гишүүн тайлан бичих**

6.4.1. Илтгэгч гишүүн Ерөнхий зөвлөлөөс баталсан загварын дагуу нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг үнэлсэн тайланг дараах агуулгаар бичнэ:

6.4.1.1. нэр дэвшигчийн талаарх ерөнхий мэдээлэл;

6.4.1.2. ярилцлага өгсөн хүн тус бүрийн нэр дэвшигчийн талаар өгсөн товч тодорхойлолт;

6.4.1.3. нэр дэвшигчийн талаарх ярилцлага бүрийн товч агуулга;

6.4.1.4. нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагын товч агуулга, илтгэгч гишүүний танилцуулсан сөрөг мэдээлэл, тайлбарт нэр дэвшигчийн өгсөн хариу тайлбар;

6.4.1.5. энэ журмын 4.8, 6.1.1.2-т заасны дагуу иргэдээс ирүүлсэн саналд хийсэн дүн шинжилгээ;

6.4.1.6. энэ журмын 6.7.2, 6.7.3-т заасан шалгуурын дагуу нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийн үнэлэмж;

6.4.1.7. шаардлагатай бусад мэдээлэл.

6.4.2.Илтгэгч гишүүн тайланд уулзалтын тэмдэглэлийг хавсаргана.

6.4.3.Илтгэгч гишүүн тайланг энэ журмын 4.8, 6.1.1.2-т заасны дагуу ирүүлсэн асуулт, саналын хуулбарын хамт Ерөнхий зөвлөлийн гишүүдэд танилцах боломжит хугацааны өмнө хүргүүлнэ. Нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийн үнэлгээнд оролцохоос татгалзан гарсан гишүүнд тайланг хүргүүлэхгүй.

6.4.4.Ерөнхий зөвлөлийн гишүүн илтгэгч гишүүний тайланг бусад этгээдэд задруулахыг хориглоно.

### **6.5.Нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлт**

6.5.1.Нэр дэвшигчийн мэргэшил, чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлт нь нэр дэвшигчийн мэргэшил, чадварын болон нэр хүндийн талаарх хэсгээс бүрдэнэ. Мэргэшил, ур чадварын талаарх хэсэгт нэр дэвшигч нь хуульчийн хувьд эрх зүйн тогтолцоо, шүүх эрх мэдлийн салбарыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмэр, мэдлэг, чадвараа түгээн дэлгэрүүлж хуваалцаж байгаа байдал, эрх зүйн тодорхой салбар, чиглэлээр мэргэшил, чадвараараа бусад хуульчид хүлээн зөвшөөрөгдсөн байдал зэргийг, нэр хүндийн талаарх хэсэгт нэр дэвшигч хуульчдын дунд танигдаж хүлээн зөвшөөрөгдсөн байдал, хуульчдын өөрөө удирдах байгууллага дахь оролцоо, хувь нэмрийг тодорхойлж тусгана.

### **6.6.Ерөнхий зөвлөлийн ярилцлага**

6.6.1.Ерөнхий зөвлөл нэр дэвшигчтэй хийх ярилцлагыг тодорхой сэдвээр хязгаарлахгүй бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн асуулт, нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг танин мэдэхэд чиглэсэн асуулт асууж болно.

6.6.2.Ерөнхий зөвлөлийн ярилцлага хийх товыг Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан хугацаанд багтаан шийдвэрлэж зарлах бөгөөд нэр дэвшигчид уг ярилцлага болохоос ажлын гурваас доошгүй өдрийн өмнө товыг мэдэгдэнэ.

### **6.7.Нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийн үнэлгээ**

6.7.1.Ерөнхий зөвлөлийн гишүүн нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг энэ журмын 6.7.2, 6.7.3-т заасан шалгуурын дагуу үнэлэх бөгөөд нэр дэвшигч тухайн шалгуурыг хэрхэн хангаж байгаа үндэслэлийн талаар санал хэлж болно.

6.7.2.Ерөнхий зөвлөлийн гишүүн нэр дэвшигчийн мэргэшлийг дараах шалгуураар доор дурдсан оноогоор үнэлж, онооны үндэслэлээ дурдана:

6.7.2.1.шүүн таслах ажлын, эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааны туршлага, чанар – 2 хүртэл оноо;

6.7.2.2.мэргэжил, мэдлэг, боловсролоо дээшлүүлж, хөгжүүлж байгаа байдал – 2 хүртэл оноо;

6.7.2.3.дүн шинжилгээ хийх, үндэслэл гаргах чадвар – 2 хүртэл оноо;

6.7.2.4. оновчтой илэрхийлэх чадвар – 2 хүртэл оноо;

6.7.2.5. харилцааны ур чадвар – 2 хүртэл оноо.

6.7.3. Ерөнхий зөвлөлийн гишүүн нэр дэвшигчийн шүүгчээр ажиллах ёс зүй, зан төлөвийг дараах шалгуураар доор дурдсан оноогоор үнэлж, онооны үндэслэлээ дурдана:

6.7.3.1. хараат бус, бие даасан байдал – 3 хүртэл оноо;

6.7.3.2. зарчимч, үнэнч, шударга байдал – 3 хүртэл оноо;

6.7.3.3. төвийг сахих чанар – 2 хүртэл оноо;

6.7.3.4. зохистой байдал – 2 хүртэл оноо;

6.7.3.5. хүмүүст тэгш хандах, хэвшмэл явцуу үзлээс ангид байдал – 2 хүртэл оноо;

6.7.3.6. хичээл зүтгэл – 2 хүртэл оноо;

6.7.3.7. шийдэмгий чанар – 2 хүртэл оноо;

6.7.3.8. ажил хэргийн болон мэргэжлийн нэр хүнд – 2 хүртэл оноо;

6.7.3.9. ажил хэргийн болон хувийн зохион байгуулалт – 2 хүртэл оноо.

6.7.4. Ерөнхий зөвлөлийн гишүүн энэ журмын 6.7.2, 6.7.3-т заасан шалгуураар нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг үнэлж оноо өгөхдөө дараах эх сурвалжид үндэслэнэ:

6.7.4.1. нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага;

6.7.4.2. нэр дэвшигчийн баримт бичиг;

6.7.4.3. нэр дэвшигчийн мэргэшил, чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлт;

6.7.4.4. сонирхсон этгээдээс хүлээн авсан санал;

6.7.4.5. илтгэгч гишүүний тайлан;

6.7.4.6. бусад.

6.7.5. Ерөнхий зөвлөлийн гишүүн нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг энэ журмын 6.7.2, 6.7.3-т заасан шалгуурын дагуу хараат бусаар, бие даан, бодитой үнэлнэ. Нэр дэвшигчийг үнэлэхдээ аравны нарийвчлалтай оноо өгч болно. Нийт гишүүний үнэлгээний дунджаар нэр дэвшигчийн шалгалт тус бүрийн үнэлгээг зууны нарийвчлалтай гаргана.

6.7.6.Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг 30 хүртэл оноогоор үнэлэх бөгөөд 20, түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг уг шалгалтад тэнцсэнд тооцно.

### **Долоо.Шүүгчид нэр дэвшигчид хориглох зүйл**

7.1.Сонгон шалгаруулалтын явцад нэр дэвшигчид дараах зүйлийг хориглоно:

7.1.1.шалгалтын үйл ажиллагаанд саад учруулах;

7.1.2.шалгалт эхлэх хугацаанаас хожимдох;

7.1.3.шалгалтын танхимд хууль, хуулийн тайлбар, ном, гарын авлагыг файл болон цаасан хэлбэрээр, гар утас, чихэвч, зөөврийн компьютер, аудио, видео техник хэрэгсэл, ноорог цаас, дэвтэр, үзэг, харандаа, флаш, зургийн аппарат зэрэг бусад адилтгах зүйлс авч орох, ашиглах;

7.1.4.шалгалтын программд нэвтрэх зөвшөөрөл өгөөгүй байхад түрүүлж нэвтрэх үйлдэл хийх;

7.1.5.шалгалтын явцад бусдад саад учруулах, ярилцах, бусдын гүйцэтгэлийг харах, ашиглах;

7.1.6.өөр хүнийг шалгалтад оролцуулах, суудлын дугаарыг сольж суух;

7.1.7.шалгалтын материалд тэмдэг, тэмдэглэгээ хийх;

7.1.8.сонгон шалгаруулалтад оролцогч сонгон шалгаруулалт зарласнаас эхлэн өргөн мэдүүлэх хүртэл хугацаанд Ерөнхий зөвлөлийн гишүүнтэй сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар биечлэн уулзах, утсаар ярих, цахимаар харилцах болон бусад байдлаар шууд болон дам нөлөөлөх;

7.1.9.шалгалтын дүн, үнэлгээнд урьдчилан нөлөөлөх гэсэн аливаа оролдлого хийх.

7.2.Нэр дэвшигч энэ журмын 7.1-д заасныг зөрчсөн тохиолдолд танхимд нэвтрүүлэхгүй байх, танхимаас чөлөөлөх, тухайн нэр дэвшигчийн шалгалт болон үнэлгээг хүчингүй болгох арга хэмжээг Ерөнхий зөвлөл тогтоол гаргаж шийдвэрлэнэ.

### **Найм.Гомдол гаргах**

8.1.Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан тухай тогтоолд тухайн иргэн, нэр дэвших эрхгүй иргэнийг бүртгэсэн тухай гомдлыг бусад нэр дэвшигч тухайн тогтоолыг цахим хуудаст мэдээлснээс хойш ажлын гурван өдрийн дотор Ерөнхий зөвлөлд бичгээр гаргах эрхтэй.

8.2.Нэр дэвшигч шалгалтын үйл ажиллагааны зохион байгуулалт, шалгалтын цахим систем болон техник, тоног төхөөрөмжийн хэвийн бус ажиллагаа, сорилын асуултад хариулах болон эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргаар авсан шалгалтын хариу зөрүүтэй талаар ажлын нэг өдрийн дотор Ерөнхий зөвлөлд бичгээр гомдол гаргах эрхтэй.

8.3.Нэр дэвшигч энэ журмын 5.4.4, 6.7.6-д заасан тогтоол гарснаас хойш ажлын нэг өдрийн дотор Ерөнхий зөвлөлд бичгээр гомдол гаргах эрхтэй.

8.4.Ерөнхий зөвлөл энэ журмын 8.1-8.3-т заасан гомдлыг үндэслэлтэй эсэхийг нягтлан шалгаж хариуг ажлын гурван өдрийн дотор бичгээр өгнө.

### **Ес.Шүүгчид нэр дэвшигчийн үнэлгээг эрэмбэлэх, өргөн мэдүүлэх**

9.1.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадвар болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалт тус бүрд өгсөн оноо, тэдгээрийн нийлбэр онооны дарааллаар эрэмбэлэн өөрийн цахим хуудаст байршуулж, нийтэд мэдээлнэ.

9.2.Ерөнхий зөвлөл эрэмбийн дагуу нийтэд мэдээлснээс хойш ажлын таван өдрийн дотор зарлагдсан орон тоогоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг шүүгчээр томилуулах саналыг, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ.

### **Арав.Бусад зүйл**

10.1.Ерөнхий зөвлөлийн ажлын алба шүүгчийн сонгон шалгаруулалтыг энэ журамд заасны дагуу явуулах техник, зохион байгуулалтыг хангана.

10.2.Ерөнхий зөвлөлийн ажлын алба шалгалт авах газар, он, сар, өдөр, эхлэх цагийг тусгасан мэдээллийг тухайн шалгалт товлосон хугацаанаас долоогоос доошгүй хоногийн өмнө Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулна.


10.3.Ерөнхий зөвлөл шалгалтын даалгаврын агуулга, ярилцлагын жишиг асуулт, тэдгээрт тавигдах шаардлага, даалгавар боловсруулах, хараат бус шинжээч оролцуулах, даалгаврын нууцлалыг хадгалах, сонгон шалгаруулалтын цахим системийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг тухайлсан журмаар зохицуулна.

10.4.Нэр дэвшигч шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцохтой холбогдон гарах зардлыг өөрөө хариуцна.

10.5.Шалгалтыг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

10.6.Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал бий болсон зэрэг зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаан бий болсон тохиолдолд сонгон шалгаруулалтыг хойшлуулж болох бөгөөд энэ тухай нэн даруй нийтэд мэдээлнэ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



## МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

**Зааварчилгаа:** Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвших тухай өргөдөл гаргахдаа энэ загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн ард хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичсэн Мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулгыг өгнө. Компьютерын программ ашиглаж бичсэн Мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулгыг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Шүүхийн ерөнхий зөвлөл (цаашид “Ерөнхий зөвлөл” гэх)-д хүргүүлнэ. Мөн Мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулгыг “Word”-ын файлаар цахим шуудангийн хаяг (сонгон шалгаруулах тухай зард заасан)-аар Ерөнхий зөвлөлд илгээнэ.

### 1.Ерөнхий мэдээлэл

Эцэг/эхийн нэр: .....

Ургийн овог: .....

Нэр: .....

Хүйс: .....

Төрсөн он: .....

Иргэний харьяалал: .....

### 2.Нэр дэвших тухай өргөдөл гаргаж буй шүүгчийн албан тушаал

Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчийн холбогдох албан тушаалыг бичнэ.

.....  
.....  
.....

### 3.Нэр дэвшсэн үндэслэл

Шүүгчийн албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/.

.....  
.....  
.....

### 4.Эрүүгийн хариуцлага

Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.

.....  
.....  
.....

### 5.Яллагдагчаар татагдсан эсэх

Шүүгчид нэрээ дэвшүүлж, өргөдөл гаргах үедээ яллагдагчаар татагдсан байгаа эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/.

.....  
.....  
.....

### 6.Харшлах өвчин, сэтгэцийн эмгэгтэй эсэх

Шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэгтэй юу /тийм, эсхүл үгүй гэж бичих, холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/.

.....  
.....  
.....

### 7.Боловсрол

Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.

.....  
.....  
.....

### 8.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих. Уг зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана/.

.....  
.....  
.....

### 9.Хуульчийн мэргэжлээр ажилласан байдал

Өргөдөл гаргагч нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөл авснаас хойш хуульчийн мэргэжлээр ажилласан ажлаа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Хуульчийн мэргэжлээр ажиллах гэдэг нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, хуулийн зөвлөх, хууль зүйн сургуулийн багш, шүүгчийн туслах зэрэг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөл заавал шаардлагатай ажил эрхэлснийг ойлгоно. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:

- албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;
- ажлын байрны тодорхойлолтын гол агуулга;



-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;

-тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, тэдгээр хүнтэй холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/.

.....  
.....  
.....

#### **10.Хуульчийн мэргэжлийн ажлын онцлог шинж**

Дараах зүйлүүдийг тодорхойлно:

10.1.таны хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны ерөнхий шинж чанар, он жилийн явцад уг шинж чанар нь хэрхэн өөрчлөгдөж байгааг үечлэн зааж бичнэ.

10.3.Хэрэв мэргэшсэн хууль зүйн салбар байгаа бол түүнийгээ бичнэ үү.

10.4.Таны мэргэжлийн үйл ажиллагаанд дараах байгууллагын эзлэх хувь:

- шүүх: %
- прокурор: %
- гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага: %
- хууль тогтоох эрх мэдлийн байгууллага: %
- өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөө: %
- төрийн бус байгууллага %
- бусад байгууллага %

.....  
.....  
.....

#### **11.Шүүн таслах ажлын туршлага: шүүгч**

Хэрэг, маргаан хянан шийдвэрлэх чиг үүрэг гүйцэтгэдэг шүүгчийн албан тушаал хашиж байсан бол тэдгээрийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, шүүх тус бүрийн харьяаллыг тодорхойлно.

11.1. Ойролцоогоор хэдэн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд шүүгчээр оролцож, шүүхийн шийдвэр гаргасан бэ?

Эдгээр хэрэг, маргааны ойролцоогоор хэдэн хувийг дараах тохиолдлууд эзлэх вэ?

- шүүхийн иргэдийн төлөөлөгчтэй хамт шийдвэрлэсэн: %
- бүрэлдэхүүнээр шийдвэрлэсэн: %
- иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: %
- эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: %
- захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: %

11.2. Сүүлийн 3 жилийн хугацаанд өөрийн бичсэн бүх шүүхийн шийдвэрийн нэр, дугаар, огноог бичнэ (хэвлэгдсэн, байршсан бол эх сурвалжийг эшлэх).

11.3. Сүүлийн 3 жилийн хугацаанд өөрийн тань гаргасан шүүхийн шийдвэрийн талаар Монгол Улсын дээд шүүхэд гомдол гаргасан бол энэ бүх шийдвэрийг жагсааж, Улсын дээд шүүхийн шийдвэрүүдийг эшлэх.

11.4. Сүүлийн 3 жилийн хугацаанд өөрийн тань шийдвэрийг дээд шатны шүүхээс өөрчилсөн бол тэдгээр шийдвэрийг эшлэж, товч агуулгыг нь тодорхойлох. Өөрийн тань гаргасан шийдвэрийн агуулга, эсхүл процесс хүчтэй шүүмжлэл дагуулсан ч дээд шатны шүүхээс хэвээр баталсан бүх шийдвэрүүдийг эшлэж, товч агуулгыг нь тодорхойлно. Энд жагсаасан бүх шийдвэрийг албан ёсоор хэвлээгүй, байршуулаагүй бол эдгээрийн хуулбарыг өгнө.

11.5. Өөрийн тань гаргасан шийдвэрүүдээс хэд нь, хэдэн хувь нь цаасаар хэвлэгдээгүй болон цахимаар байршаагүй байгаа талаар тодорхойлж, эдгээр хэвлэгдээгүй шийдвэрүүд хэрхэн хадгалагдаж байгаа талаар бичнэ.

.....  
.....  
.....

## **12. Шүүгчийн хувьд хамгийн чухал хэрэг, маргаан, шийдвэр**

12.1. Өөрөө шүүгчээр оролцсон хамгийн чухал арван хэрэг, маргаан тус бүрийн хувьд дараах мэдээллийг бичнэ: (1) хэрэг, маргааны гол агуулгын товчлол; (2) хэрэг, маргааны үр дүн; (3) хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцсон өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, прокурорын нэр, холбоо барих мэдээлэл; (4) хэвлэгдсэн бол эх сурвалжийн эшлэл, хэвлэгдээгүй бол хэрэг, маргааны нэр, дугаар, огноо болон шийдвэр, саналын хуулбар (цахим хуудаст хэвлэгдсэн бол холбогдох линк)

12.2. Өөрийн бичсэн хамгийн чухал арван шүүхийн шийдвэрийн хувьд дараах мэдээллийг бичнэ: (1) хэвлэгдсэн шийдвэрийн эшлэл; (2) хэвлэгдээгүй шийдвэрийн хуулбар; (3) тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцсон өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, прокурорын нэр, холбоо барих мэдээлэл.

.....  
.....  
.....

## **13. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлага: өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, прокурор**

13.1. Шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь таны мэргэжлийн үйл ажиллагааны хэдэн хувийг эзэлдэг вэ? Таны хянан шалгах ажиллагаанд оролцох давтамж: их, дунд зэрэг, бага, огт байхгүй. Шүүхэд өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, прокуророор оролцдог давтамж нь өөр өөр бол үүнийгээ огноотой нь хамт тодорхойлно.

13.2. Таны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон дараах тохиолдлуудын эзлэх хувь:

- иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: %
- эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: %
- захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: %
- үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа: %

13.3. Шийдвэр гаргуулахаар шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон хэрэг, маргааныхаа тоог бичнэ. Өмгөөлөгч, эсхүл прокурорын хувьд голлох, хамтрах, туслах чиг үүрэгтэй оролцсон эсэхээ тодорхойлон бичнэ.

13.4. Монгол Улсын дээд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн, эсхүл прокурорын хувьд оролцож байсан бол түүнийгээ тодорхойлно. Өөрийн гаргасан санал, нэхэмжлэл, шаардлага, хүсэлт зэргээс дөрвийг хуулбарлан өгнө. Мөн, боломжтой бол Улсын дээд шүүхийн хуралдаанд биеэр оролцож хэлсэн үгийнхээ бичлэгийг өгч болно.

13.5. Үндсэн хуулийн цэц дээр өмгөөллийн үйл ажиллагаа явуулж байсан бол түүнийгээ тодорхойлно. Өөрийн гаргасан санал, нэхэмжлэл, шаардлага, хүсэлт, мэдээлэл, өргөдөл зэргээс дөрвийг хуулбарлан өгнө. Мөн, боломжтой бол Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд биеэр оролцож хэлсэн үгийнхээ бичлэгийг өгч болно.

.....  
.....  
.....

**14.Өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, прокурорын хувьд хамгийн чухал хэрэг, маргаан**

Шүүхээр хянан шийдвэрлүүлэхэд өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, прокуророор оролцсон хамгийн чухал 10 хэрэг, маргаанаа тодорхойлно. Хэрэв шүүхийн шийдвэр цахимаар байршсан, эсхүл цаасаар хэвлэгдсэн бол эшлэх. Хэвлэгдээгүй бол дугаар, огноог бичнэ. Хэрэг, маргаан тус бүрийн агуулгыг товч тодорхойлно. Өөрийн төлөөлсөн тал хэн болох, тухайн шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон таны оролцооны гол мөн чанар юу вэ, уг хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн талаар тодорхойлно. Түүнчлэн, хэрэг тус бүр дээр доорх мэдээллийг бичнэ:

- шүүхэд төлөөлөн оролцсон огноо,
- шүүхийн нэр, тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн нэр,
- хамтрагч өмгөөлөгч (прокурор), эсрэг талын өмгөөлөгч (прокурор)-ийн нэр, хаяг, утасны дугаар.

.....  
.....  
.....

**15.Шүүгчээр ажиллах хууль зүйн мэргэшил, ёс зүй, зан төлөв**

Өргөдөл гаргагчийг тухайн шатны шүүхийн шүүгчээр ажиллах хууль зүйн мэргэшил, ёс зүй, зан төлөвтэй гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана (ийм үйл ажиллагаанд энэ загварын 12, 14 дугаарт заасан хамгийн чухал хэрэг, маргаан хамаарч байгаа бол түүнийг эшлэж болох бөгөөд өмнө бичсэн мэдээллийг дахин бичих шаардлагагүй. Энэ тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон боловч шүүхээр шийдвэрлэгдээгүй хэрэг, маргаан, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоогүй мэргэжлийн үйл ажиллагааг нэрлэж болно). Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг бичнэ.

- үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;
- үйл ажиллагааны гол агуулга;
- үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;

-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;

-тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;

-хэвлэгдсэн бол эх сурвалжийн эшлэл, түүний хуулбар.

.....  
.....  
.....

#### **16.Прокурор**

Прокуророор ажиллаж байсан бол ямар төрлийн чиг үүрэг гүйцэтгэж байсан бэ? Ямар төрлийн гэмт хэрэгт улсын яллагчаар оролцож байсан бэ?

.....  
.....  
.....

#### **17.Өмгөөлөгч, хуулийн зөвлөхийн үйлчлүүлэгч**

Өмгөөлөгч, хуулийн зөвлөх (төрийн болон бусад байгууллагад)-өөр ажиллаж байсан бол таны хууль зүйн мэргэжлийн ажлын үе тус бүрт таны мэргэжлийн үйл ажиллагаа хэний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн бэ (үйлчлүүлэгч ямар этгээд байсан бэ) гэдгийг бичнэ үү.

.....  
.....  
.....

#### **18.Эвлэрүүлэн зуучлагч, эсхүл арбитрч**

Эвлэрүүлэн зуучлагч, эсхүл арбитрчаар ажиллаж байсан эсэх, хэрэв тийм бол ийнхүү шийдвэрлэсэн хамгийн чухал 10 хэрэг, маргааны тодорхойлолт, тэдгээр оролцогчдын нэр, хаяг, утасны дугаар.

.....  
.....  
.....

#### **19.Багшлах**

Хууль зүйн сургуульд багшаар ажиллаж байсан бол тухайн албан тушаал нь үндсэн орон тоо, эсхүл гэрээт, зөвлөх багш байсан эсэхийг бичнэ. Мөн зааж байсан болон зааж байгаа хичээлүүдийн нэр, эдгээрийг ямар байгууллагад хэдэн онд зааж байсан гэдгийг мэдээлнэ. Хичээл тус бүрийн агуулга, үндсэн сэдвүүдийг товч тодорхойлно. Хэрэв танд хичээлүүдийн хөтөлбөр байвал хөтөлбөрөөс дөрвийг өгнө.

.....  
.....  
.....

#### **20.Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, мэдээлэл, холбогдох санал**

Үндсэн хуулийн цэцээр хянан шийдвэрлүүлэхээр иргэний хувьд гаргасан бүх өргөдөл, мэдээллийг жагсааж хуулбарыг хавсаргана. Шүүгчийн хувьд хэрэглэх хууль, Монгол Улсын олон улсын гэрээ Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй, эсхүл харшилсан талаар Улсын дээд шүүхэд гаргасан саналыг мөн жагсааж хуулбарыг хавсаргана. Өөрийн тань өгсөн өргөдөл, мэдээлэл, хүсэлттэй холбоотой Цэцийн шийдвэр гарсан бол уг шийдвэрийг эшлэж, тухайн шийдвэртэй уялдуулан тухайн хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа тодорхойлно.

### **21.Нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа (про боно)**

Хуульч нь дараах үйл ажиллагааг сайн дураар хөлс авахгүйгээр, эсхүл бага хөлсөөр явуулсан бол тодорхой жишээнүүдэд тулгуурлан, тухайн тохиолдол тус бүрд ямар хугацаа, хэдэн цаг зарцуулсныг бичнэ:

- төлбөрийн чадваргүй,ыы эсхүл бага орлоготой хүнд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх;
- төлбөрийн чадваргүй, эсхүл бага орлоготой хүнд туслах зорилготой байгууллагад хууль зүйн үйлчилгээ үзүүлэх;
- иргэний болон хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, баталгаажуулах зорилготой хувь хүн, бүлэг, байгууллагад хууль зүйн үйлчилгээ үзүүлэх;
- хууль зүйн үйлчилгээний хөлс төлөхөд санхүүгийн эх үүсвэрийнхээ дийлэнх хэсгийг зарцуулах байдалд байгаа төрийн, төрийн бус, боловсролын, иргэний, эсхүл сайн дурын (сайн үйлийн) байгууллагад зорилгоо биелүүлэхэд нь зориулж хууль зүйн үйлчилгээ үзүүлэх.

.....  
.....  
.....

### **22.Мэргэжлийн холбоо гишүүнчлэлийн талаар**

Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.

-Мэргэжлийн холбооны гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.

-Мэргэжлийн холбоонд эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.

.....  
.....  
.....

### **23.Бусад холбоо, байгууллагын гишүүнчлэл**

Хууль зүйн сургуулийг төгссөнөөс хойш харьяалагдаж байсан, эсхүл одоо харьяалагдаж байгаа, энэ загварын 22-т зааснаас бусад мэргэжлийн, бизнесийн, судалгааны, иргэний, сайн дурын (сайн үйлийн) болон бусад бүх байгууллагыг жагсааж бичнэ. Тухайн байгууллагын гишүүн болсон, эсхүл үйл ажиллагаанд нь оролцсон огноо, хашиж байсан аливаа албан тушаалыг бичих. Мөн энэ жагсаалтад клуб, ажлын хэсэг, редакцын зөвлөл, бусад зөвлөл, хороо зэрэг бүх гишүүнчлэлээ багтаан нэрлэнэ.

.....  
.....  
.....

## **24.Улс төрийн болон намын албан тушаал**

24.1. Ямар нэг улс төрийн намд гишүүн байсан, ажлын хөлстэй, эсхүл хөлсгүйгээр удирдах болон бусад албан тушаал эрхэлж, үйлчилгээ үзүүлж байсан бол тухайн намын гишүүнчлэл, албыг жагсааж бичнэ. Улс төрийн сонгуулийн сурталчилгаанд ямар нэг алба хаших буюу үүрэг гүйцэтгэж байсан бол нэр дэвшигч, сурталчилгааны хугацаа, өөрийн ажиллаж байсан албан тушаал, гүйцэтгэж байсан үүрэг зэрэг сурталчилгаатай холбоотой тодорхой мэдээллийг бичнэ.

24.2.Улс төрийн албан тушаал эрхэлж байгаа эсэх, эсхүл эрхэлж байсан эсэх/тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ/.

.....  
.....  
.....

## **25.Хуульчаас бусад ажил**

Их, дээд сургууль төгссөнөөс хойш цалин, урамшуулал авч, эсхүл авахгүйгээр эрхэлсэн хуульчаас бусад ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсааж, ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг бичнэ:

-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;

-ажлын байрны тодорхойлолтын гол агуулга;

-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;

-тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/.

.....  
.....  
.....

## **26.Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл**

-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.

-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.

-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.

-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

**Жич:** Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.

.....  
.....  
.....

**27.Захиргааны хариуцлага хүлээсэн, биелүүлсэн байдал:**

.....  
.....  
.....


**Өргөдөл гаргагч:**

**Эцэг/эхийн нэр:** .....

**Өөрийн нэр:** .....

**Гарын үсэг:** .....

Он, сар, өдөр: .....



**ШҮҮГЧИД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ  
ИЛТГЭГЧ ГИШҮҮНИЙ ТАЙЛАН**

/Зөвхөн ажлын хэрэгцээнд хэрэглэх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээс бусад  
этгээдэд тараах, задруулахыг хориглоно/

**Зааварчилгаа:** Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсэгт заасны дагуу илтгэгч гишүүн нь нэр дэвшигчийг судалсны үндсэн дээр тухайн нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг үнэлсэн үндэслэл бүхий тайланг энэ загварт нийцүүлэн өөрөө бичнэ.

**1.Нэр дэвшигчийн ерөнхий мэдээлэл:**

Эцэг/эхийн нэр: .....

Ургийн овог: .....

Нэр: .....

Хүйс: .....

Төрсөн он: .....

Иргэний харьяалал: .....

**2.Нэр дэвших тухай өргөдөл гаргаж буй шүүгчийн албан тушаал. Анхан, давж заалдах эсхүл хяналтын шатны шүүхийн шүүгчийн холбогдох албан тушаалыг бичнэ.**

.....  
.....  
.....

**3.Нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх ажиллагаа**

**3.1.Баримт бичиг**

Нэр дэвшигчийн гаргасан өргөдөл, мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга болон баримт бичиг тус бүрийг судлах, үнэн зөвийг нягталж үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.

.....  
.....  
.....

**3.2.Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл**

Нэр дэвшигчийн хэвлүүлсэн бүтээл /ном, өгүүлэл, тайлан зэрэг/ болон олон нийтэд өгсөн мэдээлэл /лекц, илтгэл, нээлтийн үг, ярилцлага, нийтлэл зэрэг/-ийн товч агуулгыг бичиж, нэр дэвшигчийн бичлэгийн хэв маяг, ойлгомжтой байдал, хууль зүйн дүн шинжилгээ хийх чадвар зэргийг үнэлж нэгтгэн дүгнэж бичнэ. Нэр дэвшигчээс өгсөн, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг бусад эх сурвалжаас цуглуулсан хэвлэмэл материалын хуулбарыг хавсаргана.

.....  
.....  
.....



3.3.Шүүн таслах ажлын туршлага, хянан шийдвэрлэсэн хэргийн шийдвэрийн чанар

Нэр дэвшигч шүүгчээр ажиллаж байсан буюу шүүн таслах ажлын туршлагатай бол энэ ажлын туршлагын товч агуулга, төрөл, хугацааг бичнэ. Мөн, шүүгчээр ажиллаж байхдаа хянан шийдвэрлэсэн хэргийн шийдвэрийн чанарыг дүгнэж бичнэ.

.....  
.....  
.....

3.4.Хянан шийдвэрлэх ажиллагааны туршлага, чанар

Нэр дэвшигч шүүгчээс бусад байдал (өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, прокурор, абитрч зэрэг)-аар хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байсан бол энэ ажиллагааны туршлага, товч агуулга, төрөл, хугацааг бичнэ. Мөн, хянан шийдвэрлэх ажиллагааны чанарыг дүгнэж бичнэ.

.....  
.....  
.....

3.5.Бусад ажлын туршлага, чанар

Нэр дэвшигчийн шүүн таслах болон хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад ажлын туршлага, товч агуулга, төрөл, хугацааг бичнэ. Мөн, эдгээр ажлын чанарыг дүгнэж бичнэ.

.....  
.....  
.....

3.6.Олон нийтээс ирүүлсэн асуулт, санал

Нэр дэвшигчийн талаар сонирхсон этгээдээс ирүүлсэн асуулт, саналыг судалж, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.

.....  
.....  
.....

3.7.Гаргуулж авсан баримт, мэдээлэл

Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баримт, мэдээлэл гаргуулан авсан бол тэдгээрийг судалж, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.

.....  
.....  
.....

3.8.Нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүмүүс

Нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн 10-аас доошгүй хүний талаар мэдээлнэ. Нэр дэвшигчийн удирдах албан тушаалтан, хамтран ажиллаж байсан, удирдлагад нь ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан болон бусад хүмүүс (нэр дэвших тухай хүсэлтэд дурдагдсан, эсхүл дурдагдаагүй)-тэй холбоо барьж ярилцлага хийсэн байна.

.....  
.....  
.....

3.9.Нэр дэвшигчийн талаарх ярилцлагын товчлол

Нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадвар /дүн шинжилгээ хийх, үндэслэл гаргах, шийдвэр гаргах зэрэг/, ажлын туршлага, мэргэжлийн ёс зүй, зан төлөвийн талаар хүмүүстэй хийсэн ярилцлагын товч агуулгыг нэгтгэн үндэслэлтэйгээр дүгнэж бичнэ. Үүнд ярилцагчаас нэр дэвшигчийн талаар өгсөн зэрэг, сөрөг мэдээллийг багтаана. Нэр дэвшигч шүүгчид тавих болзол, шаардлага тус бүрийг хангасан эсэх талаар ярилцагчаас асууж хөтөлсөн тэмдэглэлийн гол агуулгыг бичнэ. Хэрэв сөрөг мэдээлэл өгсөн бол тухайн мэдээллийг мэдэх бусад хүн, эх сурвалжийг нэрлэхийг ярилцагчаас хүснэ. Үүний мөрөөр сөрөг мэдээлэл дээр хяналтын ярилцлага, судалгааг нэмж хийнэ.

.....  
.....  
.....

### 3.10.Нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагын товчлол

Нэр дэвшигчийн талаарх ярилцлагуудын явцад гарсан сөрөг мэдээллийн талаар нэр дэвшигчтэй ганцаарчлан ярилцаж тэмдэглэл хөтөлнө. Нэр дэвшигчтэй илтгэгч гишүүний ганцаарчлан хийсэн ярилцлагын гол агуулгыг нэгтгэн үндэслэлтэйгээр дүгнэн бичнэ. Ярилцлагуудын явцад хөндөгдсөн гол асуудлууд, илтгэгч гишүүний сэтгэгдэл, бусад хүнтэй хийсэн ярилцлагуудын үед хүлээн авсан сөрөг мэдээлэлд нэр дэвшигчийн өгсөн хариу тайлбар зэрэг мэдээллийг бичнэ.

.....  
.....  
.....

### 3.11.Бусад хэлбэрээр цуглуулсан мэдээлэл

Нэр дэвшигчийн талаар үнэлгээ өгөхөд зайлшгүй шаардлагатай мэдээллийг бусад хэлбэрээр цуглуулсан бол энэ талаар танилцуулж, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.

.....  
.....  
.....

## 4.Шүүгчид тавих болзол, шаардлагыг хангасан эсэх үнэлгээ

### 4.1.Монгол Улсын иргэн мөн эсэх

Монгол Улсын иргэн байх шаардлагыг хангаж буй эсэхийг цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан үнэлж, үндэслэлтэйгээр дүгнэж тодорхой, ойлгомжтой бичнэ.

.....  
.....  
.....

### 4.2.Шүүгч өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар

Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар (60 нас)-т хүрээгүй байх шаардлагыг хангаж буй эсэхийг цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан үнэлж, үндэслэлтэйгээр дүгнэж тодорхой, ойлгомжтой бичнэ.

.....  
.....  
.....

### 4.3.Эрүүгийн хариуцлага

Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан үнэлж, үндэслэлтэйгээр дүгнэж тодорхой, ойлгомжтой бичнэ.

-Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан эсэх, прокурор, эсхүл өмгөөлөгчөөр дагнан 10-аас доошгүй жил ажилласан эсэх, магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их, дээд сургуульд 10-аас доошгүй жил багшилсан эсэх.

.....  
.....  
.....

#### 4.10.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн

Шүүгчид нэр дэвших үед Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа эсэх, эсхүл сүүлийн нэг жилийн хугацаанд уг албан тушаалыг эрхэлж байсан эсэхийг цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан үнэлж, үндэслэлтэйгээр дүгнэж тодорхой, ойлгомжтой бичнэ.

.....  
.....  
.....

#### 4.11.Шүүхийн сахилгын хорооны гишүүн

Шүүгчид нэр дэвших үед Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаж байгаа эсэх, эсхүл сүүлийн нэг жилийн хугацаанд уг албан тушаалыг эрхэлж байсан эсэхийг цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан үнэлж, үндэслэлтэйгээр дүгнэж тодорхой, ойлгомжтой бичнэ.

.....  
.....  
.....

#### 4.12.Улс төрийн болон намын удирдах албан тушаал хашиж байсан эсэх

Нэр дэвшигчийн хувьд сүүлийн зургаан жилд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй байх шаардлагыг хангасан эсэхийг цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан бичнэ.

.....  
.....  
.....

#### 5.Шүүгчээр ажиллах түвшний мэргэшилтэй эсэх

Нэр дэвшигч нь шүүгчээр ажиллах түвшний мэргэшилтэй эсэхийг цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дараах шалгуураар үнэлж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ:

- 1.шүүн таслах ажлын, эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааны туршлага, чанар;
2. мэргэжил, мэдлэг, боловсролоо дээшлүүлж, хөгжүүлж буй байдал;
3. дүн шинжилгээ хийх, үндэслэл гаргах чадвар;
- 4.оновчтой илэрхийлэх чадвар;
- 6.харилцааны ур чадвар.

.....  
.....  
.....

6.Шүүгчээр ажиллах ёс зүй, зан төлөвтэй эсэх

Нэр дэвшигч нь шүүгчээр ажиллах ёс зүй, зан төлөвтэй эсэхийг цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дараах шалгуураар үнэлж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ:

- 1.хараат бус, бие даасан байдал;
2. зарчимч, үнэнч, шударга байдал;
- 3.төвийг сахих чанар;
- 4.зохистой байдал;
- 5.хүмүүст тэгш хандах, хэвшмэл явцуу үзлээс ангид байдал;
- 6.хичээл зүтгэл;
- 7.шийдэмгий чанар;
- 8.ажил хэргийн болон мэргэжлийн нэр хүнд;
- 9.ажил хэргийн болон хувийн зохион байгуулалт.

.....  
.....  
.....

7.Дүгнэлт

Илтгэгч гишүүн нь цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэлд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг нэгтгэн үнэлж шүүгчид тавих болзол, шаардлагыг хангасан эсэхийг дүгнэж, үндэслэлээ тайлбарлан бичнэ.

.....  
.....  
.....


**Илтгэгч гишүүн**

**Овог, нэр:** .....

**Гарын үсэг:** .....

**Он, сар, өдөр:** .....

Шүүхийн зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт



## НЭР ДЭВШИГЧИЙН МЭРГЭШИЛ, ЧАДВАР, НЭР ХҮНДИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТИЙН ЗАГВАР

/Зөвхөн ажлын хэрэгцээнд хэрэглэх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээс бусад этгээдэд тараах, задруулахыг хориглоно/

**Зааварчилгаа:** Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7.3-т заасны дагуу илтгэгч гишүүн нь нэр дэвшигчийг судалсны үндсэн дээр тухайн нэр дэвшигчийн мэргэшил, чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг гаргана.

### 1.Нэр дэвшигчийн ерөнхий мэдээлэл:

Эцэг/эхийн нэр: .....

Ургийн овог: .....

Нэр: .....

Хүйс: .....

Төрсөн он: .....

Иргэний харьяалал: .....

### 2.Нэр дэвшигчийн мэргэшил, чадварын талаар

Мэргэшил, чадварын талаарх хэсэгт нэр дэвшигч нь хуульчийн хувьд эрх зүйн тогтолцоо, шүүх эрх мэдлийн салбарыг хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмэр, мэдлэг, чадвараа түгээн дэлгэрүүлж хуваалцаж байгаа байдал, эрх зүйн тодорхой салбар, чиглэлээр мэргэшил, чадвараараа бусад хуульчдад хүлээн зөвшөөрөгдсөн байдал зэргийг тусгана. Тухайлбал:

- сүүлийн 3 жилийн хугацаанд хамрагдсан үргэлжилсэн сургалтын чиглэл, хуульчийн үргэлжилсэн сургалтад тогтмол хамрагдаж, багц цагаа хангаж байсан эсэх;
- эрх зүйн тодорхой чиглэлээр мэргэшиж ажилласан байдал;
- эрх зүйн мэдлэг, боловсролоо дээшлүүлэх чиглэлээр суралцсан байдал;
- сүүлийн жилүүдэд ажилласан хэргийн тоо;
- сүүлийн жилүүдэд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг тасралтгүй эрхэлж байсан байдал;
- хуульчийн хувьд эрх зүйн тогтолцоо, шүүх эрх мэдлийн салбарыг хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмэр, мэдлэг, чадвараа түгээн дэлгэрүүлж хуваалцаж байгаа байдал.

.....  
.....  
.....

### 3. Нэр дэвшигчийн нэр хүндийн талаар

Нэр хүндийн талаарх хэсэгт нэр дэвшигч хуульчдын дунд танигдаж хүлээн зөвшөөрөгдсөн байдал, хуульчдын өөрөө удирдах байгууллага дахь оролцоо, хувь нэмрийг тодорхойлж тусгана. Тухайлбал:

- хуульчдын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаан дахь мэргэжлийн оролцоо, оруулсан хувь нэмэр;

- хуульчийн хувьд аливаа бүтээл, илтгэл зэрэг нь бусдын бүтээл, илтгэл зэрэгт эшлэгдсэн байдал;

- сүүлийн 3 жилийн хугацаанд мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар ямар нэгэн гомдлын дагуу хариуцлага хүлээж байсан эсэх;

- захиргааны зөрчил гаргаж, хариуцлага хүлээсэн тохиолдолд биелүүлж байсан эсэх;

- согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн гэх үндэслэлээр албадлагын болон бусад арга хэмжээ авагдаж байсан эсэх.

.....  
.....  
.....

**Илтгэгч гишүүн**

**Овог, нэр:** .....

**Гарын үсэг:** .....

**Он, сар, өдөр:** .....

-oOo-